



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (563)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүний тухай*

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- *Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны аравдугаар сарын 14

№38 (563)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

656. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 283 1065

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

657. Ажилд томилох тухай Дугаар 04 1068

658. Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүний тухай Дугаар 06 1069

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

659. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 07 1071

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

НҮБ-ын мандаттай Энхийг сахиулах ажиллагааны 10 дугаар ээлжинд оролцож хүмүүнлэгийн олон улсын ажиллагаанд Монгол албан үүргээ нэр төртэй биелүүлсэн дор Улсын цэргийн багуудыг үүрэг гүйцэтгэхэд хувь дурдсан хүмүүсийг одон, медалиар нэмэр оруулсан болон "Иракийн эрх чөлөө" шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Цэрэнбалжидын Дашзэвэг - Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа ЭСЯ-ны элчин зөвлөх

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

Цэвэгсүрэнгийн Тогоо - ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Дамдингийн Чагнаадорж - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Рэндоогийн Даваадорж - ЗХЖШ-ын Ар талын газрын эрүүл мэндийн хэлтсийн дарга, Ар талын газрын Зэвсэглэл, техник эрхэлсэн орлогч, хэлтсийн дарга, хурандаа
2. Цэндээсүрэнгийн Доржготов - ЗХЖШ-ын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа
3. Чимэддоржийн Ерөөлцэнгэл - БХЯ-ны



4. Санжмятавын Одонбаяр - ЗХ-ний 150 дугаар ангийн салааны захирагч, ахлах ахлагч

5. Өндгөний Эрдэнэ-Очир - ЗХ-ний 327 дугаар ангийн захирагч, хурандаа

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сураагийн Ганбаатар - ЗХ-ний 123 дугаар ангийн жагсаал ангийн дарга, сургагч, ахлагч

Энхийг дэмжих хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн, ахмад

2. Самбуудоржийн Зоригтбаатар - ЗХ-ний 310 дугаар ангийн Гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч

5. Гунгаагийн Хоролмаа - ЗХ-ний 016 дугаар ангийн жолооч, засварчин, ахлах ахлагч

3. Цагаанхүүгийн Идэрбат - ЗХ-ний 065 дугаар ангийн 086 дугаар салбарын захирагч, ахлах дэслэгч

6. Пүрэвийн Цэдэвсүрэн - ЗХ-ний 256 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

4. Маждагийн Мөнхбаяр - ЗХЖШ-ын

7. Дашдоржийн Чулуунбат - ЗХ-ний 120 дугаар ангийн Хадгалах тасгийн нярав, засварчин, ахлах ахлагч

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИАР:

1. Сүрэнгийн Баасанхүү - БХ-ын дэд сайд,

13. Лувсангийн Эрдэнэчулуун - Гадаад хэргийн сайд асан

2. Михайл Борбаатар - БХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал

14. Очирын Энхцэцэг - Монгол Улсаас НҮБ-д суугаа айнгын төлөөлөгч

3. Азадын Баатарцогт - ХХЕГ-ын дарга, хошууч генерал

15. Равжаагийн Мөнхөө - ГХЯ-ны Америк, Ойрхи дорнод, Африкийн газрын дэд захирал

4. Аюушийн Ганбат - ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, хошууч генерал

16. Пунцагийн Пүрэвбазар - ЗХЖШ-ын Холбоо цэргийн удирдлагын автоматжуулалтын хэлтсийн дарга, хурандаа

5. Найдангийн Энхбаялаг - ЗХЖШ-ын Сургалт зохион байгуулалт эрхэлсэн орлогч дарга, бригадын генерал

17. Дүйнхоржавын Баянжав - ЗХЖШ-ын Цэргийн алба, соёл хүмүүжлийн хэлтсийн дарга, хурандаа

6. Мягмардоржийн Буянжаргал - БХЯ-ны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын орлогч дарга, хурандаа

18. Чүлтэмийн Баярсайхан - ЗХ-ний 032 дугаар ангийн захирагч, хурандаа

7. Өвгөнхүүгийн Батмөнх - БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн удирдлагын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хурандаа

19. Цасчихэрийн Бямбажав - ЗХ-ний 327 дугаар ангийн хөгжимчин, дэд ахлагч

20. Батцэнгэлийн Ганбаатар - ЗХ-ний 310 дугаар ангийн захирагч, хурандаа

8. Цэрэнчимэдийн Зоригтбаатар - МЗХ-ны ерөнхийлөгч, Азийн залуучуудын холбооны тэргүүн дэд ерөнхийлөгч

21. Данаагийн Баатар - ЗХ-ний 232 дугаар ангийн захирагч, хурандаа

9. Дашдондогийн Баярсайхан - Монгол Улсаас АНУ-д суугаа ЭСЯ-ны батлан хамгаалахын атташе, хурандаа

22. Чогсомын Балдар - ЗХ-ний Клиникийн төв госпиталийн мэс заслын зөвлөх эмч, бэлтгэл хурандаа

10. Тогмогийн Хүрэлбаатар - Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа

23. Отгивын Чадраабал - ЗХЖШ-ын Хүний нөөц, нийгмийн хамгааллын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

11. Шаравжамцын Бүүвээбаатар - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын хэлтсийн дарга

24. Жамъянгийн Батхүү - "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга

12. Энэбишийн Сумъяа - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт

25. Ганжуурын Уранчимэг - ЗХ-ний 189 дүгээр ангийн РХАБ-ын мэргэжилтэн



26. Цэвээний Төмөртоого - ЗХ-ний 311 дүгээр ангийн ахлах тогооч

27. Баттөмөрийн Энхбаяр - ХЗДХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

28. Очирын Маш-Эрдэнэ - ТЕГ-ын ДШМС газрын дарга

29. Чимэддоржийн Амарболд - ЦЕГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч

30. Нацагдоогийн Баяраа - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт асан

31. Дашийн Алтаншагай - ЗХ-ний 032 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

32. Лхагвасүрэнгийн Амартүвшин - ЗХ-ний 150 дугаар ангийн сумлагч, дэд ахлагч

33. Батхандын Амгаланбаатар - ЗХ-ний 330 дугаар ангийн Ар талын даргын орлогч, хошууч

34. Чулуунбатын Ариунболд - ЗХ-ний 326 дугаар ангийн батарейны техникийн орлогч, ахлах дэслэгч

35. Болдбаатарын Ариундэлгэр - ЗХ-ний 013 дугаар ангийн шуурхай бүлэг-1 зангилгааны станцын дарга жолооч, дэд ахлагч

36. Төмөртогтохын Баасанхүү - ЗХ-ний 013 дугаар ангийн бүлгийн дарга, ахлах дэслэгч

37. Бүжинлхамын Баасанцэрэн - ЗХ-ний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч

38. Амгаланбаатарын Бадамдорж - ЗХ-ний 150 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч

39. Бөхчулууны Банзрагч - ЗХ-ний 123 дугаар ангийн компрессорчин жолооч, дэд ахлагч

40. Содномпилийн Батболд - ЗХ-ний 011 дүгээр ангийн цахилгаанчин, дэд ахлагч

41. Сарангэрэлийн Батзориг - ЗХ-ний 327 дугаар ангийн жолооч, цахилгаанчин, ахлагч

42. Дазын Батмөнх - ЗХ-ний 124 дүгээр ангийн станцын дарга, жолооч, ахлах ахлагч

43. Батбилэгийн Батпүрэв - ЗХ-ний 234 дүгээр ангийн салааны жолооч, ахлагч

44. Баасайн Батсүх - ЗХ-ний 011 дүгээр ангийн засварчин, ахлагч

45. Жамбалын Баттулга - ЗХ-ний 336 дугаар ангийн техник хадгалах агуулахын орлогч дарга, ахлах дэслэгч

46. Цэрэндэндэвийн Баттулга - ЗХ-ний 016 дугаар ангийн ротын захирагчийн техникийн орлогч, ахмад

47. Болдбаатарын Баярмэнд - ЗХ-ний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

48. Ёндонгомбын Баяртулга - ЗХ-ний 330 дугаар ангийн гранатомётчин, дэд ахлагч

49. Дашзэвэгийн Баясгалан - ЗХ-ний 016 дугаар ангийн гал сөнөөгч, жолооч, ахлагч

50. Цэвээнхүүгийн Буяндэлгэр - ЗХ-ний 336 дугаар ангийн штабын дарга, хошууч

51. Амартөрийн Бямбасүрэн - ЗХ-ний 016 дугаар ангийн гал сөнөөгч, ахлагч

52. Цэцгээгийн Ганбаатар - ЗХ-ний 084 дүгээр ангийн автын засварчин, ахлагч

53. Цэдэнсодномын Ганбилэг - ЗХ-ний Клиникийн төв госпиталийн мэс заслын их эмч

54. Гочоогийн Ганзориг - ЗХ-ний 330 дугаар ангийн наводчик, дэд ахлагч

55. Цэрэндагвын Гансүх - ЗХ-ний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч

56. Батбаярын Гантөмөр - ЗХ-ний 084 дүгээр ангийн бүлгийн дарга, дэслэгч

57. Мишкэгийн Гантулга - ЗХ-ний 234 дүгээр ангийн салааны гүүрчин жолооч, ахлагч

58. Хүрэлбаатарын Гийх-Оргил - ЗХ-ний 150 дугаар ангийн гранатомётчин, дэд ахлагч

59. Халтарын Даваацэрэн - ЗХЖШ-ын Сургалтын бодлогын хэлтсийн дарга, хурандаа

60. Цогтгэрэлийн Доржбат - ЗХ-ний 330 дугаар ангийн тасгийн жолооч, дэд ахлагч

61. Шукрайн Еркинбек - ЗХ-ний 123 дугаар ангийн агуулахын дарга, ахмад

62. Энхбаярын Лхагвасүрэн - ЗХ-ний 330 дугаар ангийн тусгай салааны техникч, дэд ахлагч

63. Лувсангийн Лувсандорж - ЗХ-ний Клиникийн төв госпиталийн чих хамар хоолойн их эмч, ахмад

- | | |
|---|---|
| <p>64. Лхайсүрэнгийн Мөнгөнбаяр - ЗХ-ний 330 дугаар ангийн ротын пулемётчин, дэд ахлагч</p> <p>65. Улаанхүүгийн Мөнгөнзаяа - ЗХ-ний 336 дугаар ангийн зэвсгийн нярав-засварчин, дэд ахлагч</p> <p>66. Мягмарын Мөнхбат - ЗХ-ний 120 дугаар ангийн авто тээврийн салааны захирагч, дэслэгч</p> <p>67. Хүрэлбаатарын Мөнхзаяа - Дотоодын цэргийн 809 дүгээр ангийн довтлогч, дэд ахлагч</p> <p>68. Хаддоржийн Мөнх-Оргил - ЗХ-ний 336 дугаар ангийн гал сөнөөгч, ахлагч</p> <p>69. Пүрэвийн Мөнх-Эрдэнэ - ЗХ-ний 326 дугаар ангийн салааны захирагч, ахлах ахлагч</p> <p>70. Бямбын Мягмарсүрэн - ЗХ-ний 014 дүгээр ангийн компрессорчин-жолооч, дэд ахлагч</p> <p>71. Батсүхийн Мянганбаяр - ЗХ-ний 336 дугаар ангийн авто техникийн дарга, дэслэгч</p> <p>72. Жаргалсайханы Насанбуян - ЗХ-ний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч</p> <p>73. Цогтоогийн Нэргүй - ЗХЖШ-ын цэргийн тагнуулын газрын жолооч, ахлагч</p> <p>74. Түвшинжаргалын Нямцэрэн - ЗХ-ний 123 дугаар ангийн соёлын төвийн дарга, дэслэгч</p> <p>75. Сүмхүүгийн Оргилбаяр - ЗХ-ний 256 дугаар ангийн радиотелеграфчин, дэд ахлагч</p> <p>76. Зулзагын Отгонбаяр - ЗХ-ний 015 дугаар ангийн шалган нэвтрүүлэх байрын жижүүр, дэд ахлагч</p> | <p>77. Дашцэрэнгийн Оюунбат - ЗХ-ний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, дэд ахлагч</p> <p>78. Жаргалсайханы Өсөхбаяр - ЗХ-ний 167 дугаар ангийн штабын даргын орлогч, оператив тасгийн дарга, дэд хурандаа</p> <p>79. Эрдэнэбилэгийн Сайнхүү - ЗХ-ний 014 дүгээр ангийн жагсаалын дарга, ахлагч</p> <p>80. Нямсүрэнгийн Сүхбаатар - ЗХ-ний 016 дугаар ангийн сургууль, байлдааны мотобуудлагын батальоны захирагч, хошууч</p> <p>81. Ядамжавын Төгс-Эрдэнэ - ЗХ-ний 015 дугаар ангийн харуулчин, дэд ахлагч</p> <p>82. Цэндээгийн Төмөр-Очир - ЗХ-ний 330 дугаар ангийн засварчин, жолооч, дэд ахлагч</p> <p>83. Орсоогийн Үл-Олдох - ЗХ-ний 330 дугаар ангийн химичин-ариутгагч, дэд ахлагч</p> <p>84. Жамъянхоролын Үүрцайх - ЗХ-ний 150 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч</p> <p>85. Мягмарсүрэнгийн Цэрэндорж - ЗХ-ний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч</p> <p>86. Шижирбаатарын Чулуунбат - ЗХ-ний 123 дугаар ангийн миномётын батарейны сумлагч-жолооч, дэд ахлагч</p> <p>87. Энхтайваны Энхбаатар - ЗХ-ний 123 дугаар ангийн тусгай холбооны мэргэжилтэн, ахлагч</p> <p>88. Ширэндэвийн Энхбаяр - ЗХ-ний 014 дүгээр ангийн механик, жолооч, ахлах ахлагч</p> |
|---|---|

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий газрын даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

Данзангийн Сандаг-Очирыг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хариуцсан ажилтан гүйцэтгэж байхаар тус тус тогтоосугай.

1. Монгол Улсын Засгийн газар, гадаад орны Засгийн газар хооронд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

4. Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

2. Тухайн оронтой явуулж байгаа хамтын ажиллагааны цар хүрээ, зонхилох чиглэл, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай уялдуулан хуралдаанд Монголын талаас оролцох төлөөлөгч, шинжээчийн бүрэлдэхүүнийг комиссын Монголын хэсгийн дарга нар тухай бүр томилж байхаар тогтоосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2006 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 117 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 309 дүгээр тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Монгол-Орос, Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн нарийн бичгийн дарга нарын газрын бүрэлдэхүүнийг Монголын хэсгийн дарга нар томилж байхаар, бусад комиссын Монголын хэсгийн нарийн бичгийн даргын үүргийг Гадаад харилцааны яамны тухайн орны

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
**ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**
С.БАТБОЛД
**Засгийн газрын 2008 оны 06 дугаар
тогтоолын хавсралт**

ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОМИССУУДЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН

1. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга –Эрүүл мэндийн сайд

5. Худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллах Монгол-Болгарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга –Тэргүүн шадар сайд

Дарга –Эрүүл мэндийн сайд

сайд

Орлогч дарга –Гадаад харилцааны дэд

2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

6. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Украины Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

Дарга –Шадар сайд

Дарга -Батлан хамгаалахын сайд

Орлогч дарга –Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

7. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Унгарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

3. Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан Хорооны Монголын хэсэг
Дарга –Шадар сайд

Дарга –Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд

4. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол-Италийн Засгийн газар хоорондын холимог Комиссын Монголын хэсэг

8. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг

<p>Дарга –Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд</p> <p>9. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд</p> <p>10. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</p> <p>11. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Кубын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Батлан хамгаалахын сайд</p> <p>12. Монгол-Туркийн эдийн засаг, худалдааны хамтарсан Хорооны Монголын хэсэг Дарга –Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</p> <p>13. Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Финландын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд</p> <p>14. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Беларусийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд</p> <p>15. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Чехийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд</p> <p>16. Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд</p> <p>17. Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</p> <p>18. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг</p>	<p>Дарга –Хууль зүй, дотоод хэргийн сайд</p> <p>19. Монгол-Британийн дугуй ширээний ярилцлагын Монголын хэсэг Дарга –Эрдэс баялаг, эрчим хүчний сайд</p> <p>20. Монгол-Канадын дугуй ширээний ярилцлагын Монголын хэсэг Дарга –Эрдэс баялаг, эрчим хүчний сайд</p> <p>21. Монгол Улс, ХБНГУ-ын Зээл, тусламжийн асуудал зохицуулах хэлэлцээний Монголын хэсэг Дарга –Сангийн сайд</p> <p>22. Монгол-Францын Соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны хамтарсан Комиссын Монголын хэсэг Дарга –Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд</p> <p>23. Монгол-Энэтхэгийн хамтын ажиллагааны хамтарсан Хорооны Монголын хэсэг Дарга –Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд</p> <p>24. Монгол-Оросын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд Комиссын Монголын хэсэг Дарга –Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга</p> <p>25. Монгол Улс-Европын Холбооны хамтын ажиллагааны Хамтарсан хорооны дэргэдэх худалдаа, хөрөнгө оруулалтын Дэд хорооны Монголын хэсэг Дарга –Гадаад харилцааны дэд сайд</p> <p>26. Монгол-Кувейтийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга</p> <p>27. Монгол-Катарын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Гадаад харилцааны дэд сайд</p> <p>28. Монгол Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Сангийн сайд</p> <p>29. Монгол Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга –Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</p>
---	--

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.20 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, гишүүн П.Очирбат, Ж.Амарсанаа/илтгэгч/, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар С.Энхтуулыг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч Баянгол дүүргийн 17 дугаар хорооны иргэн Д.Батсүх, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар оролцоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "...хууль зүйн туслалцаа авах...эрхтэй..." гэсэн хэсэг, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны иргэн Д.Батсүх Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"...Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.", 2 дахь хэсэгт "Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ." хэмээн заасан байна.

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй..." хэмээн иргэний Үндсэн эрхтэй холбогдуулан баталгаажуулжээ.

Үндсэн хуулийн дээрх заалтыг улам бүр баталгаажуулж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "өмгөөлөгч нь ...хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй," мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.7, 36 дугаар зүйлийн 36.3.3-д өмгөөлөгч авах эрхтэйг тус тус заажээ.

Гэтэл 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлаг шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө

өмгөөлөгчөөр сонгоно" хэмээн заасан нь Үндсэн хуулийн дээрх үзэл санааг зөрчсөн төдийгүй Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах боломжийг хааж, мэргэжлийн хууль зүйн туслалцааны үнэ цэнэ, агуулга, ач холбогдлыг алдагдуулж байна.

Өөрөөр хэлбэл харшлаг шалтгаангүй хэн боловч Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохоор ойлгогдож байгаа юм.

Түүнчлэн мэргэжлийн хуульч/ийн бус хүмүүс Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож, хууль зүйн мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт гаргаж чадахгүй, үр нөлөөтэй хууль зүйн туслалцаа үзүүлж чадаагүйнхээ төлөө мэргэжлийн болон ёс зүйн ямар ч хариуцлага хүлээхгүй байгаа нь иргэний эрх зүйн байдлыг дордуулан хохироход хүргэж байна.

Үндсэн хуулийн дээрх зөрчлийг арилгах нь хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хамгаалах, шүүх эрх мэдлийн нэр хүндийг өргөж, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлэх юм. ...

Дээр дурдсан тайлбар, үндэслэлүүдээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн ... заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах...эрхтэй..." гэснийг, Тавин тавдугаар зүйлийн "1 Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй. 2. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байгаа талаар дүгнэлт гаргаж өгөхийг хүсье." гэжээ.

Хоёр. Улсын Их Хурлын даргын 2008 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 83 дугаар захирамжаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"...1. Хүний эрхийг хангах баталгааны чухал бүрэлдэхүүн хэсэг бол өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх бөгөөд Үндсэн хуулиар үүнийг баталгаажуулж өгсөн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалтыг дангаар нь авч үзэх боломжгүй бөгөөд хуулийн бусад заалтуудтай уяалдуулан авч үзэх хэрэгтэй юм. Хүн өөрийгөө өмгөөлөх



эрхтэйгээс гадна өмгөөлөгчөө өөрөө сонгох, солих эрхтэй бөгөөд энэ нь тухайн этгээдийн чөлөөт сонголттой шийдвэрлэгдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39.1-д "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгоно." гэж заасан. Шүүх энэ эрхийг хангах боломжийг бүрдүүлж өгөх ёстой. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй тохиолдолд өөрөө итгэж байгаа, өөртөө хэрэгтэй тэр туслалцааг үзүүлж чадна гэсэн этгээдийг сонгож, өмгөөлүүлэх эрхээ эдлэх боломжийг мөн хуулийн заалтаар олгож байгаа юм.

Нэн даруй хууль зүйн туслалцаа авах нь өөрийгөө хамгаалуулах эрхээ хангах урьдчилсан нөхцөл болно. Иймд хуулийн дээрх заалт иргэн Д.Батсүхийн тайлбарласнаар "сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах боломжийг хааж, мэргэжлийн хууль зүйн туслалцааны үнэ цэнэ, агуулга, ач холбогдлыг алдагдуулж байна." гэж үзэж болохгүй юм.

2. Харин ч мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй тухайн тохиолдолд шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөө сонгож авснаар өөрийгөө өмгөөлөх эрх нь бас давхар баталгаажиг байгаа юм. Энэ тохиолдолд иргэний эрх зүйн байдлыг дордуулан хохироход хүргэж байгаа биш эсрэгээрээ давхар хамгаалалттай болох нөхцөл бүрдэж байгаа юм. Хууль тогтоогч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль ёсыг дээдлэн хэрэгжүүлэх нөхцөл хангагдах ёстой гэж үзэж энэ заалтыг оруулсан болно.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...хууль зүйн туслалцаа авах ...эрхтэй..." гэсэн хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна." гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөө сонгоно" гэсэн заалт нь хууль зүйн боловсролгүй, хуульчийн сонгон шалгаруулалт болон өмгөөлөгчийн мэргэжлийн шалгаруулалтад орж тусгай зөвшөөрөл аваагүй иргэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрхтэйгээр оролцох хууль зүйн үндэслэл бий

болгосноор байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн Үндсэн хуульд заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах боломжийг хязгаарласан байна.

Аливаа иргэн мэргэжлийн өмгөөлөгчийн эрх эдэлж, үүрэг биелүүлж, хариуцлага хүлээн өмгөөлөгчийн талаар гаргасан хууль, журмыг мөрдөж, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжгүй юм. 1994 оны Өмгөөллийн тухай хуулийг 2002 онд шинэчлэн найруулахдаа дээрх заалтыг хассан боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шилжүүлэн нэмж оруулсан нь ойлгомжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөө сонгоно" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "...хууль зүйн туслалцаа авах ...эрхтэй..." гэсэн хэсэг, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ." гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2008 оны 10 дугаар 10-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай харуу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

П.ОЧИРБАТ
ЖАМАРСАНАА
Д.НАРАНЧИМЭГ
Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1